



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

**Нийслэлийн Өмчийн харилцааны  
газрын тээврийн хэрэгслийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/336 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотойгоор тус газарт актаар хүлээн авсан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 104,453,010.00 (нэг зуун дөрвөн сая дөрвөн зуун тавин гурван мянга арав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэгдэл өртөггүй 4 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу бүртгэлээсээ хасахыг Өмчийн бүртгэл мэдээллийн хэлтэс (Н.Хашцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.САЙХАНБАЯР

D:\НӨХГ\Тушаал 2023\А тушаал.docx

1150500021

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
 2023 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн  
 А/131 дугаар тушаалын хавсралт

**Сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдах тээврийн хэрэгслийн жагсаалт**

д/д	Автомашин марк, улсын дугаар	Үйлдвэр- лэсэн/ Монголд ашиглаж эхэлсэн он	Зориула лт, аль улсад үйлдвэр лэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэг дэл өртөг	Эвдрэл гэмтэл	Сэлбэг болон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах доод үнэ (төгрөг)
1	Hyundai, Aero Town 43-36 УНД	2004/202 0	Суудал БНСУ Цагаан	KM99H7MJD5KB1K003	865985	17,850,210.0	17,850,210.00	-	Явах эд ангийн ашигт нормоос хэтэрсэн элэгдэл, караказ зэвэрч муудсан, зорчигчийн заал болон шалны битүүмж алдагдсан, хөдөлгүүрийн түлш, маслын зарцуулалт ихэссэн зэрэг нь Монгол	800,000
2	Hyundai, Elantra 66-73 УНХ	2010/201 5	Суудал БНСУ Цагаан	KMHDT41BABU246995	815689	23,000,000.0	23,000,000.00	-	улсын замын	800,000
3	Hyundai, Elantra 42-67 УНХ	2010/201 5	Суудал БНСУ Цагаан	KMHDT41BABU247752	876489	23,000,000.0	23,000,000.00	-	хөдөлгөөний дүрмийн 2-р хавсралтын 3.1, 3.2-р заалтуудыг зөрчиж	800,000
4	Hyundai, Starex 42-10 УНХ	2011/201 2	Суудал БНСУ Саарал	KMFWBX7RACU462192	959568	40,602,800.0	40,602,800.00	-	байгаа бөгөөд цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон гэж акт тогтоосон байна.	800,000
Нийт дүн						104,453,010.0	104,453,010.0	-		3,200,000